Golomt Capital®

ТАВААРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Алт
Газрын тос

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.07.04

Golomt Capital®

АЛТНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 7-р сарын 04

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

Холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ нэмэгдүүлснээр ам.долларын ханш чангарч алтны ханш гурван долоо хоногт дараалан унаж байна. Спот алтны үнэ 0.1%-аар буурч, унц нь 1804.81 ам.доллар болжээ.

Энэ хооронд дэлхийн хоёр дахь алт хэрэглэгч Энэтхэг улс худалдааны алдагдлыг бууруулах зорилгоор алтны импортын үндсэн татвараа 7.5%-аас 12.5% болгон нэмэгдүүлсэн нь алтны эрэлтийн хэт төлөвийг сулруулж байна.

Гуравдугаар улиралд баяр наадмын үеэр биет алтны худалдаа сайн байдаг ч импортын татвар нэмэгдэж байгаа нь эрэлтэд сөргөөр нөлөөлөх нь дамжиггүй юм.

Татвар, бас бус хүчин зүйлээс улбаалан алтны эрэл сул байгаа тул энэтхэгийн биет алтны дилерүүд бараандаа хөнгөлөлт урамшуулал зарлахад хүргэж байна.

Сүүлийн 4 сарын хугацаанд үргэлжилж байгаа уналтын чиг хандлага дуусах болоогүй байна. 5 дугаар сараас хойш бүрэлдэж бий болсон туг загвар дэмжлэгийн цэгээ доошоо сэтлэн гарсан нь уналтын чиг хандлага үргэлжлэх магадлалыг улам бүр нэмэгдүүлж байна. Алт нь 1820 орчим руу хүрч эсэргүүцэл аваад уналтаар 1717 орчим ам.долларт хүрэх боломжтой.

Мэдэгдэл: *Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*

Golomt Capital®

ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал: **2022 оны 7-р сарын 04**

ОПЕК-ийн олборлолт буурч, Ливийн эмх замбараагүй байдал, ОХУ-д тавьсан хориг арга хэмжээний улмаас нийлүүлэлт хүрэлцээгүй хэвээр байгаа ч дэлхийн эдийн засгийн уналтаас болгоомжлох айдас нэмэгдэж байгаа нь газрын тосны ханшийг унагаж байна.

Брент маркийн нефтийн фьючерс 35 цент буюу 0.3%-аар буурч, баррель нь 111.28 ам.долларт хүрчээ. АНУ-ын Баруун Техасын (WTI) түүхий нефтийн үнэ 32 цент буюу 0.3%-иар буурч 108.11 ам.долларт хүрчээ.

ОПЕК газрын тосны өдрийн гарцаа 275,000 баррелиар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байсан ч газрын тос экспортлогч орнуудын байгууллагын (ОПЕК) гишүүн 10 орны гарц зургадугаар сард өдөрт 100,000 баррелиар буурч, 28.52 сая баррель гарсан байна. Энэ тэдний төлөвлөгөөнөөс хол зөрүүтэй тоо юм.

Нигери болон Ливийн улсуудын газрын тосны гарц буурч байгаа ч Саудын Араб болон бусад томоохон үйлдвэрлэгчид дутууг нь нөхөж байна. Гэхдээ нөхцөл байдал энэ хэвээр цааш үргэлжилбэл ОПЕК үйлдвэрлэлийн шинэ квотоо биелүүлэх магадлалыг улам бүр багасгах болно.

Ливийн экспортын хэмжээ өдөрт 865,000 орчим баррелиас 365,000 баррель болтлоо буурчээ.
Норвегийн газрын тос, байгалийн хийн ажилчид энэ долоо хоногт хийхээр төлөвлөж байсан ажил хаялт нь тус улсын газрын тосны олборлолтын хэмжээг өдөрт 130,000 баррелиар бууруулж болзошгүй юм.

Мэдэгдэл: *Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*